

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2024.12.15

Өлгий

Д/д	Шалгуур үзүүлэлт	Биелэлт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	- Өлгий, Дэлүүн, Улаанхус, Цэнгэл, Алтай, Толбо сумын болон Цагааннуур чөлөөт бүсийн Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн. Ногооннуур сумын ХХЕТ, Баяннуур сумын 1 дүгээр багийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө дуусах шатандаа байна. 2024 онд Буянт, Алтанцөгц, Сагсай сумдын төвийн хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр, Цэнгэл, Улаанхус сумдын төлөвлөгөөнд тодотгол оруулах хөрөнгийг шийдвэрлүүлсэн, ажил нь эхэлж хийгдэж байна. - Өлгий сумын төв хэсгийг дайран өнгөрдөг Ховд голын эрэг дагуух үерийн хамгаалалтын данг сэргээх, хүчитгэх, шинээр барих ажлыг 156 сая төгрөгөөр хийлгэв. - Өлгий сумын 3, 12-р багийн нутаг дэвсгэрт Бөхөн уулын энгэр хэсгээр дайран өнгөрдөг улсын чанартай авто замд 28 ширхэг үер усны хоолой байгаа ба хооронд нь ямар нэгэн холболт хийгдээгүй шууд айлууд руу үерийн ус орж ирэх өндөр эрсдэлтэй. Эдгээрийн хамгийн их эрсдэлтэй 10 хоолойны доод хэсэгт үерийн усыг хуримтлуулах, эрчийг нь сааруулах 8 хөв цөөрөм, мөн замын дэд хэсэгт хамгаалалтын далантай том хэмжээний цөөрмийг 142,6 сая төгрөгөөр хийлгэв. - Үерийн далан дайран өнгөрөх 600 метр онцгой объектийн газрыг чөлөөлж дахин 1.2 км газрын зураг төсвийг шинэчлэн хийлгэсэн. Уг зураг төсөв магадлалаар орж батлагдсан боловч 2024 оны төсөвт санхүүжилтийн асуудал нь шийдвэрлэгдээгүй байна. - Бүх сумдын газар өмчлөгчийн цаасан хувийн хэргийг	100%

		цахимжуулж, аймагт төвлөрүүлэн архивлаж байна.	
1.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Төрийн үйлчилгээний цэсэд төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг тухай бүр шинэчлэн https://shilen.gov.mn , https://bayan-olqii.gazar.gov.mn/ байгууллагын цахим хуудсанд тус тус байршуулсан.	100%
1.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Газрын даргын баталсан 2024 оны 02-15/03 тоот “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжаар 6 сумд хяналт шалгалт хийсэн ба зөрчил илэрсэн Өлгий, Цэнгэл, Алтай, Буянт сумдын Засаг дарга, газрын даамлуудын үйл ажиллагааг 35.1 кодтой “Өмчлөх, эзэмших, ашиглах эрх олголт, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах хяналтын хуудас” болон газар зохион байгуулалт, газрын кадастрын мэдээллийн сан, кадастрын чиглэлийн холбогдох асуудлаар Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй хамтарсан шалгалт хийж 32 заалт бүхий 3 албан шаардлага өгч биелэлтийг нь хангуулан хууль зөрчсөн 23 захирамжийг хүчингүй болгосон.	100%
1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Үгүй	
1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргатай хийсэн гэрээ, аймгийн Засаг даргатай хийсэн гэрээ, Барилгын хөгжлийн төвийн захиралтай хийсэн гэрээ, Барилга, хот байгуулалтын сайдтай аймгийн Засаг даргын хийсэн гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг тус тус хуулийн хугацаанд хүргүүлсэн.	100%
1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн	Байгууллагын bayan-ulgii@gazar.gov.mn цахим хуудасны Хууль, эрх зүй цэсэд салбарын хэмжээнд дагаж, мөрдөж	100%

	акт;	байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тогтмол байршуулж байна.	
1.7.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг зэргийг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст ил тод байршуулсан.	100%
1.8.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	2024 онд нийт ирсэн бичиг 521, өргөдөл гомдол 169, явуулсан албан бичиг 478 хүлээн авч бүртгэж албажуулан холбогдох албан тушаалтанд шилжүүлж, хариутай 408 албан бичгийн хариуг нь хуулийн хугацаанд өгч шийдвэрлэсэн. Ирсэн бичиг, явсан бичиг, өргөдөл гомдлыг цахимжуулаад цахим архив үүсгэсэн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүрийн дараа сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна. Газартай холбоотой 2024 оны жилийн эцсийн байдлаар 3270 гаруй иргэн ААНБ-ын хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн /egazar.gov.mn/ байна.	100%
1.9.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Баян-Өлгий аймаг нийт 4570489 га нутаг дэвсгэртэй. Үүний 4292868.82 га буюу 93.93 хувь нь хөдөө аж ахуйн газар, 21857.36 га буюу 0.48 хувь нь хот, тосгон, бусад суурин газар, 16265.22 га буюу 0.36 хувь нь зам, шугам сүлжээний газар, 119689.14 га буюу 2.61 хувь нь ойн сан бүхий газар, 119808.46 га буюу 2.62 хувь нь усны сан бүхий газар тус тус байна. Аймгийн хэмжээнд 13040 иргэн 1584,5 га газрыг өмчилж байна. Мөн 15976 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 1836 га газрыг эзэмшдэг бол гадаадын хөрөнгө оруулалттай 9 аж ахуйн нэгж 250,7 га газрыг ашигладаг. Хуульд заасан хугацаанд Газрын төлбөр, татварын удирдлагын нэгдсэн системээр дамжуулан нийт 14103 хүчинтэй гэрээнд газрын төлбөрийн 475 сая төгрөгийн	100%

		нэхэмжлэлийг үүсгэж аймгийн татварын хэлтэс болон сумдын газрын даамал, татварын байцаагч нарт хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар 365 сая төгрөг төвлөрч гүйцэтгэл нь 97%-тай байна.	
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Бүтэн жилийн байдлаар байгууллагын цахим https://bayan-olqii.gazar.gov.mn/ болон фейсбүүк пэйж хуудсанд 152 мэдээ, мэдээллийг тус тус байршуулан нээлттэй, ил тод, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Сагсай сумын Газрын даамлын сул орон тоо, Барилгын асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны сонгон шалгаруулалтыг зарлаж өгөх тухай 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 52, 296 дугаар албан тоотоор Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлсэн.	100%
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Тусгай шалгалт өгч Сагсай сумын газрын даамлын сул орон тоонд тэнцсэн Б.Өнөрбек, Барилгын асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд тэнцсэн М.Асу нарыг Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 19, 11 дүгээр сарын 04-ний өдрийн 61 дүгээр нэр дэвшүүлэх тогтоолын дагуу тухайн албан тушаалуудад газрын даргын 2024 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн Б/08, 11 дүгээр сарын 14-ний өдрийн Б/15 дугаар тушаалаар хуулийн хугацаанд тус тус томилон сул орон тоог нөхсөн.	100%
2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог байгуулж үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Ёс зүйн зөрчил гаргасан Дэлүүн сумын газрын даамалд газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/53 дугаар тушаалаар сануулах арга хэмжээ авсан.	100%

2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Байгууллагын цахим хуудасны “ Хүний нөөцийн ил тод байдал ” цэсэд “Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх Журам батлах тухай Засгийн газрын 382 дугаар тогтоол мөн хүний нөөцийн холбогдох 14 дүрэм журмыг хэрэгжүүлэн үр дүнг байршуулсан. -Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, -Баян-Өлгий аймгийн ГХБХБГ-ын албан хаагчдын мэдээлэл, - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2024 оны төлөвлөгөө, түүний хагас жилийн биеэлэлт - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын сургалт, хөгжлийн төлөвлөгөө, хагас жилийн биелэлт, - Хүний нөөцийн хөгжил, стратеги төлөвлөгөө, - ГХБХБГ-ын Хөдөлмөрийн дотоод журам зэргийг тогтмол шинэчилж байна.	100%
2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Засгийн газрын 2009 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 143 дугаар тогтоол, ГЗБГЗЗГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/10 дугаар тушаалын дагуу байгууллагын бүтэц, орон тоо, хүний нөөцийн ил тод байдлыг хангах, мэдээллийг веб сайтад байршуулж, тухай бүрд тогтмол шинэчилж байна.	100%
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Улирал бүр албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж “Бүрэн хангалттай, “хангалттай” үнэлгээ авсан албан хаагчдад Газрын даргын 2024 оны Б/10, А/47, А/54 дугаар тушаалаар улирлын мөнгөн урамшууллыг тус тус олгосон.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Байгууллагын 2024 оны жилийн төсөв, 2023 оны төсвийн гүйцэтгэл, 2025 оны төсвийн төслийг shilendans.gov.mn веб сайтад мөн байгууллагын цахим хуудсанд байршуулж,	100%

		мэдээ, мэдээллийг иргэд чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн. Биелэлт 100%-тай байна.	
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн хоёрны өдөр өссөн дүнгээр гаргаж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлдэг. Мөн байгууллагын мэдээллийн самбарт байршуулж, шилэн дансны төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл хэсэгт, сар бүрийн төсвийн гүйцэтгэл болон 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайланг тус тус оруулан иргэдийн төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг бүрэн хангаж ажиллаж байна. Биелэлт 100%-тай байна.	100%
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Байгууллагын 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайланг, дүгнэлтийн хамт бүрэн эхээр нь шилэн дансанд байршуулсан.	100%
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	2024 онд хууль тогтоомжийн дагуу тухайн байгууллагын төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт ороогүй болно. Энэ талаар дансны мэдээлэл хэсэгт байршуулсан.	100%
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	2024 оны 12 сарын байдлаар төсвийг зарцуулалтын дагуу ашиглаж, ямар нэгэн өглөг, авлага үүсээгүй. Шилэн дансны төсвийн хэмнэлт хэтрэлтийн тайлан хэсэгт сар бүр мэдээллийг тогтмол оруулдаг.	100%
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	2024 онд таван сая болон түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, бэлтгэн нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн дансны мэдээлэлд тухайн бүрд нь оруулж, мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг, гүйлгээ тус бүрээр, гүйлгээний утга, хүлээн авагчийн нэрийн хамт тухай бүр шилэн дансанд оруулдаг.	100%
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй	Газрын даргын 2024 онд гаргасан хөрөнгө зарцуулах тушаал, шийдвэрийг тухай бүрд нь шилэн дансанд	100%

	адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	оруулсан.	
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансны хөтлөлтийг, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж аймгийн Төрийн аудитын газар болон ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн баталгаажуулж, биелэлтийг гаргаж, шилэн дансны мэдээлэл хэсэгт байршуулсан.	100%
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 04 ний өдрийн хурлаар 2024 онд худалдан авах хөрөнгийн жагсаалтыг батлуулж, шилэн дансанд байршуулсан.	100%
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	2023 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг бүрэн эхээр нь шилэн дансанд байршуулав. 2024 оны цахим дэлгүүрээс худалдан авах үндсэн хөрөнгийн нийлүүлэх гэрээг шилэн дансанд байршуулж, ил тод байдлаар ханган ажиллаж байна.	100%
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Хамаарах мэдээлэл байхгүй.	100%
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр байхгүй байна.	100%
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн	Хамаарах мэдээлэл байхгүй.	100%

.	судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;		
3.15	Хууль тогтоомжид заасан бусад.	Хамаарах мэдээлэл байхгүй.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал			
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Төрийн үйлчилгээний цэсд төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг тухай бүр шинэчлэн https://shilen.gov.mn , https://bayan-olgii.gazar.gov.mn/ тус тус байршуулсан. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ булангийн ГАЗРЫН ХАРИЛЦАА цэснээс: ✓ Мэдэгдэх хуудас цахимаар хэвлэж авах заавар, ✓ Давуу эрхээр газар өмчлөх заавар, ✓ Эзэмшиж, ашиглаж буй газрын зориулалт өөрчлөх заавар, ✓ Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх заавар, ✓ Газар эзэмшүүлэх гэрээ хэрхэн хэвлэх заавар, ✓ Газар өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх заавар, ✓ Газрын эрхээ бусдад цахимаар шилжүүлэх заавар, ✓ Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацаа сунгах заавар, ✓ Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх дуусгавар болгох заавар, ✓ Эзэмшиж, ашиглаж буй газрын талбайн хэмжээ өөрчлөх заавар, ✓ Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр	100%

		газар өмчилж авах заавар, ✓ Газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаар авах заавар, ✓ Газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээ нөхөн авах заавар, ✓ Геодезийн хэмжилзүйн лаборатори, ✓ Газрын зургийн нэг маягийн суурь, ✓ GNSS-ийн байнгын ажиллагаатай станц, ✓ Геодезийн байнгын цэг, тэмдэгт, ✓ Газар зүйн нэр, ✓ Газар өмчлөгчдөд зөвлөмж, ✓ Дансны мэдээлэл, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ цэснээс: ✓ Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах дараалал , ✓ Барилгын тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл, шаардлага, ✓ Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн үйлчилгээний хөлс, ✓ БҮАЗ-ийн гэрчилгээний загвар, ✓ Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ дахин олгох , ✓ Системд бүртгүүлэх гарын авлага, ✓ БҮАТЗ олгох, хяналт тавих журам /БХБС-ын 2021 оны 147 дугаар тушаал/, нэмэлт, чиглэл, ✓ Мэдээллийн сангийн журам /БХБС-ын 2021 оны 139 дүгээр тушаал, ✓ Аргачлал батлах тухай , ✓ Үйл ажиллагааны тайлан нөхөх зааварчилгаа, ✓ Тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих үйлчилгээний хөлсний хэмжээ , ✓ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын хооронд	
--	--	--	--

		байгуулсан гэрээний загвар , ✓ Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам , ✓ БХБ-ын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ , ✓ Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэх заавар болон хэмжээ, ✓ Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ дахин олгох , ✓ БМҮ-ийн тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлага, ✓ БМҮ-ийн дансны мэдээлэл , ✓ БМҮ-ийн тусгай зөвшөөрөл хүсэлт гаргах дараалал, ✓ БМҮТЗ-ийн гэрчилгээний загвар, ✓ БМҮ-ийн системд бүртгүүлэх гарын авлага, ✓ БМҮ-ийн тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих үйлчилгээний хөлсний хэмжээ, ✓ Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж төлөх заавар , ✓ Тусгай зөвшөөрлийн систем /ААНБ/, ✓ тавигдах шаардлага МАЯГТЫН ЗАГВАРУУД цэснээс: ✓ Бүрдүүлэх материал, ✓ Газрын харилцааны талаар иргэн, <u>ААНБ</u>-уудад үзүүлэх үйлчилгээний хураамж, ✓ Газар өмчлөх тухай хүсэлт гаргах маягт, ✓ Газар эзэмших тухай хүсэлт гаргах маягт, ✓ Газар ашиглах тухай хүсэлт гаргах маягт , ✓ "Газар эзэмших эрхийг шилжүүлж авснаар үүсэх эрх, үүргийг хүлээн зөвшөөрч байгаа тухай мэдэгдэл"-ийн маягт,	
--	--	--	--

		✓ Улсын бүртгэлийн мэдүүлгийн хуудас ✓ Бүрдүүлэх материал ✓ Газар эзэмших хүсэлт илгээх ӨРГӨДЛИЙН ЗАГВАРУУД ✓ Эзэмшил газрын зориулалтыг өөрчлөх, ✓ Эзэмшил газрын талбайн хэмжээг өөрчлөх, ✓ Улсын бүртгэлийн дугаар авах , ✓ Газар эзэмших эрхийн хугацааг сунгах, ✓ Газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх, ✓ Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, ✓ Эзэмшил газраа өмчлөх, ✓ Газар өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, ГАЗРЫН ЦАХИМ СИСТЕМЭЭР ИЛГЭЭХ БОЛОМЖТОЙ ХҮСЭЛТҮҮД цэснээс: Газар өмчлөх эрхтэй холбоотой цахим системээр илгээх боломжтой хүсэлтүүд 1. Газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх 2. Төрөөс нөхөн олговортойгоор эргүүлэн авах 3. Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах 4. Давуу эрхээр газар өмчлөх 5. Газар өмчлөх эрх дуусгавар болгох 6. Газрын кадастрын мэдээллийн санд барилга, хаяг дугаар бүртгүүлэх 7. Нэгж талбар нэгтгэх, хуваах 8. Зураг төсөл зөвшилцөх Газар эзэмших эрхтэй холбоотой цахим системээр илгээх боломжтой хүсэлтүүд	
--	--	---	--

		1. Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх 3. Эзэмшиж буй газрын зориулалт өөрчлөх 4. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах 5. Газар эзэмших гэрчилгээг нөхөн авах 6. Эзэмшиж буй газрын талбайн хэмжээ өөрчлөх 7. Эзэмшил газраа хэсэгчлэн шилжүүлэх 8. Газар эзэмших эрх дуусгавар болгох 9. Эзэмшиж буй газраа өмчлөх 10. Газар эзэмших эрхийн улсын бүртгэлийн дугаар авах 11. Газрын кадастрын мэдээллийн санд барилга, хаяг дугаар бүртгүүлэх 12. Нэгж талбар нэгтгэх хүсэлтийг цахимаар илгээх боломжтой.	
4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Хамааралгүй	
Хэсгийн дундаж хувь:			100%
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Бүтэн жилд ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам”, “Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөмж”, “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”, “Аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын төслүүд болон нэгж талбарын хувийн хэргийг хөтлөх	100%

		журмын хэрэгжилтийн явцад тулгарч буй бэрхшээлийн талаарх саналаа албан тоотоор хүргүүлсэн. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлтэд тусгах саналыг ГЗБГЗЗЕГ-т албан тоотоор хүргүүлсэн. Бүтэн жилд ГХБХБГ-ын өөрийн зүгээс олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа захиргааны хэм хэмжээний акт байхгүй байна.	
5.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	үгүй	
5.3.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем буюу WWW.EGAZAR.GOV.MN сайтад тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орсон нэмэлт өөрчлөлт, тодотголыг тухай бүрд нэгж талбар бүрээр байршуулсан.	100%
5.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Аймгийн ГХБХБГ Өлгий сумын 11-р багийн нутаг дэвсгэрт 604 м2 газрыг аймгийн Засаг даргын 2006 оны 392 дугаар захирамжаар, 504 м2 газрыг 2019 оны А/172 дугаар захирамжаар эзэмшдэг. Газрын мэдээлэл нь цахим системд бүрэн орсон.	100%
5.5.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	үгүй	
5.6.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын	Үгүй	

	дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;		
5.7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Үгүй	
5.8.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Үгүй	
5.9.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хот байгуулалтын кадастрын цахим системээр дамжуулан 26 архитектур төлөвлөлтийн даалгавар, 6 зураг төсөл боловсруулах даалгавар, 15 барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, 14 барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлт гаргаж Иргэн, аж ахуйн нэгжүүдэд үйлчлэн үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэн ажиллаж байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлтийг https://shilen.gov.mn , https://bayan-olgii.gazar.gov.mn/ цахим хуудсанд тус тус байршуулсан. Тус мэдээллийг байгууллагын цахим хуудасны БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ булангийн БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХЫГ ЗӨВШӨӨРСӨН УЛСЫН	100%

		КОМИССЫН ДҮГНЭЛТ цэснээс харах боломжтой.	
5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Үгүй	
5.11	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Үгүй	
5.12	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Үгүй	
5.13	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Үгүй	
Хэсгийн дундаж хувь:			100%
Хэрэгжилтийн дундаж хувь:			100%

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА /Ж.ЕСТАЙ/